



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/542

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14.02,41.2.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахим хөгжил инновац,харилцаа холбооны сайд, Аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим орчинд зөв байя 3-р аян Улсын хэмжээнд эхэлсний дагуу Хөвсгөл аймагт ажиллах Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвөөс хамтран зохион байгуулж буй Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх хамтарсан багийн Хөвсгөл аймагт ажиллах томилолтын зардал 1,608,880 (Нэг сая зургаан зуун найман мянга найман зуун наян төгрөг) “Цахимд зөв байя” 3 дугаар шатны сургалтыг Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, аймаг, сумдын Төрийн албан хаагчид, иргэдэд зохион байгуулах арга хэмжээний зардалд 6,291,000 (арван долоон сая есөн зуун хорин нэгэн мянга зургаан зуун тавин)төгрөгийг,Аймгийн Веб сайт хөгжүүлэлтэд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.“Цахим орчинд зөв байя” аяны зардалд Төрийн албаны ерөнхий удирдлага зохицуулалт хөтөлбөрийн Цахим аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын үзүүлэлт сайжруулахаас 7,900,000 (Долоон сая есөн зуун мянга) төгрөгийг, Цахим аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Веб сайт хөгжүүлэх зардлаас 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулахыг нягтлан бодогч (Э.Анхцэцэг) -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ